

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий Боловсролын 5-р Сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.02.25 № 1-6/249

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5-Р СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.МИЖИДСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

442505255

Бусад асуудал

2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 96.8 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	749,717,769.32	424,212,871.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	437,641,550.27	104,553,418.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	437,641,550.27	104,553,418.11
3121	Төгрөг	437,641,550.27	104,553,418.11
31211	Төрийн сангийн харилцах	437,641,550.27	104,553,418.11
33	АВЛАГА	572,955.00	2,752,591.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	572,955.00	572,955.00
33500	Байгууллагаас авах авлага	-	2,179,636.00
35	БАРАА МАТЕРИАЛ	311,503,264.05	316,906,862.35
351	Түүхий эд материал	1,707,000.00	1,698,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,510,000.00	1,510,000.00
35130	Эм боох материал	197,000.00	188,000.00
354	Хангамжийн материал	309,796,264.05	315,208,862.35
35410	Бичиг хэргийн материал	29,259,047.00	27,443,697.00
35420	Аж ахуйн материал	113,312,091.20	122,117,289.60
35460	Хүнсний материал	15,634,231.00	14,056,980.90
35470	Бусад хангамжийн материал	151,590,894.85	151,590,894.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,909,903,094.00	1,868,564,001.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,909,903,094.00	1,868,564,001.89
392	Биет хөрөнгө	1,705,951,094.00	1,664,612,001.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,669,362,566.00	1,669,362,566.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(411,769,879.47)	(431,120,703.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	685,640,069.40	599,377,965.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(421,410,654.78)	(458,905,227.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	263,802,587.35	274,641,587.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	(188,725,849.71)	(82,451,589.33)
39209	Зам, гүүрийн байгууламж	97,723,671.06	97,723,671.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	(93,528,399.03)	(93,655,814.22)
39217	Ном	104,856,983.18	89,639,546.33
393	Биет бус хөрөнгө	203,952,000.00	203,952,000.00
39301	Програм хангамж	3,077,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,077,000.00)	(1,727,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	203,952,000.00	203,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,659,620,863.32	2,292,776,873.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,997,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,997,000.00	-
413	Өглөг	25,997,000.00	-
4136	Бусад өглөг	25,997,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	25,997,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,633,623,863.32	2,292,776,873.35
51	Засгийн газрын хувь оролцоо	2,633,623,863.32	2,292,776,873.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,640,057.09	2,498,640,057.09
512	Хуримтлагдсан үр дүн	(488,772,033.57)	(829,619,023.54)
51210	Өмнөх үеийн үр дүн	(488,772,033.57)	(488,772,033.57)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(340,846,989.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	623,755,839.80	623,755,839.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,659,620,863.32	2,292,776,873.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,486,904,815.21	3,921,694,891.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,019,353.00	158,997,731.56
120	Нийтлэг татварын бус орлого	72,019,353.00	158,997,731.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,019,353.00	158,997,731.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,583,800.00	53,824,300.00
120017	Үнэ төлбөргүй авсан орлого Үндсэн хөрөнгө	50,965,190.00	14,587,656.16
120018	Үнэ төлбөргүй авсан орлого Бараа материал	4,470,363.00	90,585,775.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,414,885,462.21	3,762,697,159.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,061,880,200.00	3,401,653,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,061,880,200.00	3,401,653,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	353,005,262.21	361,043,259.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	353,005,262.21	361,043,259.93
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,210,107,412.54	4,241,815,788.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,210,107,412.54	4,241,815,788.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,062,445,860.54	4,184,819,648.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,181,448,748.82	2,903,968,074.22
210101	Үндсэн цалин	1,488,706,047.86	1,842,522,407.53
210102	Нэмэгдэл	623,883,434.28	991,123,307.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,528,263.00
210104	Урамшуулал	68,859,266.68	52,794,096.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,017,953.03	367,658,277.52
210201	Тэтгэврийн даатгал	150,468,948.80	249,527,183.94
210202	Тэтгэмжийн даатгал	22,322,624.77	29,516,175.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,316,777.76	14,812,362.20
210204	Ажилгүйдлийн даатгал	10,916,635.99	14,551,955.63
210205	Эрүүл мэндийн даатгал	44,992,965.71	59,250,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,005,262.21	356,499,309.93
210301	Гэрэл, цахилгаан	19,306,300.21	26,619,047.05
210302	Түлш, халаалт	292,964,826.00	292,964,800.00
210303	Цэвэр, бохир ус	37,734,136.00	36,915,462.88
2104	Хангамж, бараа материалын зардал	50,816,406.00	67,531,671.00
210401	Бичиг хэрэг	14,541,210.00	28,884,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,275,196.00	38,646,771.00
2105	Нормативт зардал	318,740.00	305,410,934.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	318,740.00	382,285.00
210502	Хоол, хүнс	-	305,028,649.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,543,950.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,543,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,435,106.85	60,835,684.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,828,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,607,106.85	60,835,684.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,403,643.63	118,371,747.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,944,037.52	47,096,715.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	379,062.48	460,312.47
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	129,080,543.63	70,814,718.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,661,552.00	56,996,140.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	147,661,552.00	54,816,504.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,851,819.00	48,706,504.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,809,733.00	6,110,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,179,636.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий Боловсролын 5-р Сургуулийн 2025
оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,179,636.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	276,797,402.67	(320,120,897.30)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	20,601,194.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	20,601,194.01
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал – Үндсэн хөрөнгө	-	124,898.66
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(20,726,092.67)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	276,797,402.67	(340,846,989.97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,431,469,262.21	3,816,521,459.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,583,800.00	53,824,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,583,800.00	53,824,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,583,800.00	53,824,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,583,800.00	53,824,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,414,885,462.21	3,762,697,159.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,061,880,200.00	3,401,653,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,061,880,200.00	3,401,653,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	353,005,262.21	361,043,259.93
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	353,005,262.21	361,043,259.93
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,160,456,389.93	4,149,609,592.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,160,456,389.93	4,149,609,592.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,997,554,807.93	3,919,271,700.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,191,086,724.85	2,903,968,074.22
210101	Үндсэн цалин	1,498,344,023.89	1,842,522,407.53
210102	Нэмэгдэл	623,883,434.28	991,123,307.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,528,263.00
210104	Урамшуулал	68,859,266.68	52,794,096.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	253,498,649.02	367,658,277.52
210201	Тэтгэврийн даатгал	163,949,644.79	249,527,183.94
210202	Тэтгэмжийн даатгал	22,322,624.77	29,516,175.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,316,777.76	14,812,362.20
210204	Ажилгүйдлийн даатгал	10,916,635.99	14,551,955.63
210205	Эрүүл мэндийн даатгал	44,992,965.71	59,250,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	350,005,262.21	356,499,309.93
210301	Гэрэл, цахилгаан	19,306,300.21	26,619,047.05
210302	Түлш, халаалт	292,964,826.00	292,964,800.00
210303	Цэвэр, бохир ус	37,734,136.00	36,915,462.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,543,950.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,543,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,765,106.85	66,770,084.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,828,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,937,106.85	66,770,084.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	129,199,065.00	219,832,003.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,131,565.00	193,086,003.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,067,500.00	26,746,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,901,582.00	230,337,892.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	162,901,582.00	228,158,256.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	158,073,850.00	222,048,256.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий Боловсролын 5-р Сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,827,732.00	6,110,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,179,636.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,179,636.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	271,012,872.28	(333,088,132.16)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	60,915,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,915,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	60,915,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	33,145,000.00	-
223001	Бусад хөрөнгө	27,770,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(60,915,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	210,097,872.28	(333,088,132.16)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		437,641,550.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	437,641,550.27	104,553,418.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ДҮН	БУСАД	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(488,772,033.57)	-	2,633,623,863.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(488,772,033.57)	-	2,633,623,863.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(340,846,989.97)		(340,846,989.97)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	(829,619,023.54)	-	2,292,776,873.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,285,395,400.00	4,147,429,956.09	(137,965,443.91)	96.8%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,285,395,400.00	4,147,429,956.09	(137,965,443.91)	96.8%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,053,608,500.00	3,919,271,700.09	(134,336,799.91)	96.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,981,229,400.00	2,903,968,074.22	(77,261,325.78)	97.4%
210101	Үндсэн цалин	1,953,154,100.00	1,842,522,407.53	(110,631,692.47)	94.3%
210102	Нэмэгдэл	998,660,900.00	991,123,307.19	(7,537,592.81)	99.2%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,528,263.00	17,528,263.00	
210104	Урамшуулал	29,414,400.00	52,794,096.50	23,379,696.50	179.5%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,653,600.00	367,658,277.52	(4,995,322.48)	98.7%
210201	Тэтгэврийн даатгал	253,404,500.00	249,527,183.94	(3,877,316.06)	98.5%
210202	Тэтгэмжийн даатгал	29,812,300.00	29,516,175.75	(296,124.25)	99.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,906,100.00	14,812,362.20	(93,737.80)	99.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	14,906,100.00	14,551,955.63	(354,144.37)	97.6%
210205	Эрүүл мэндийн даатгал	59,624,600.00	59,250,600.00	(374,000.00)	99.4%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,676,800.00	356,499,309.93	(2,177,490.07)	99.4%
210301	Гэрэл, цахилгаан	26,640,000.00	26,619,047.05	(20,952.95)	99.9%
210302	Түлш, халаалт	292,964,800.00	292,964,800.00	-	100.0%
210303	Цэвэр, бохир ус	39,072,000.00	36,915,462.88	(2,156,537.12)	94.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,543,950.00	(456,050.00)	90.9%
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,543,950.00	(456,050.00)	90.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,930,700.00	66,770,084.92	(1,160,615.08)	98.3%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	67,930,700.00	66,770,084.92	(1,160,615.08)	98.3%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	268,118,000.00	219,832,003.50	(48,285,996.50)	82.0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	241,372,000.00	193,086,003.50	(48,285,996.50)	80.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,746,000.00	26,746,000.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,786,900.00	228,158,256.00	(3,628,644.00)	98.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	231,786,900.00	228,158,256.00	(3,628,644.00)	98.4%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	231,786,900.00	222,048,256.00	(9,738,644.00)	95.8%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,110,000.00	6,110,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,285,395,400.00	3,816,521,459.93	(468,873,940.07)	89.1%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,921,718,600.00	3,401,653,900.00	(520,064,700.00)	86.7%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,921,718,600.00	3,401,653,900.00	(520,064,700.00)	86.7%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	363,676,800.00	361,043,259.93	(2,633,540.07)	99.3%
132001	Орон нутгийн төсвөөс	-	361,043,259.93	361,043,259.93	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	53,824,300.00	53,824,300.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	53,824,300.00	53,824,300.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		437,641,550.27		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		104,553,418.11		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 169,268.2 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулж алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Ахмадад олгосон 2,600.0 мянган төгрөгөөс ХХОАТ суутгалгүй олгосныг Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлан /ТТ-12/ тайлангийн Суутгаагүй олгосон орлогын мэдээнд тайлагнаж залруулсан.
- Нийт 168,986.8 мянган төгрөгийн зардлын гүйлгээг эдийн засгийн ангилал буруу тайлагнасныг залруулсан.
- 21.4 мянган төгрөгийн 2 үндсэн хөрөнгийг хасах утгатай тайлагнасан.

5.1 Төлбөрийн акт

2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ гэж заасны дагуу 2025 оны санхүүгийн тайланг хугацаанд нь хүргүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 36 нэр төрлийн үндсэн хөрөнгийг данснаас хасаагүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн стандартын дагуу хэрэв тухайн хөрөнгийг цаашид үргэлжлүүлэн ашиглах бол дахин үнэлгээ хийлгэж, цаашид ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, дахин ашиглахгүй бол данснаас хасах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
								Залруулсан		Залруулаагүй	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХОАТ суутгаагүй олгосон орлого	1	260.0	1	260.0			1	260.0		
2	Эдийн засгийн ангилал буруу тайлагнасан.	1	168,986.8			1	168,986.8	1	168,986.8		
3	Үндсэн хөрөнгийг хасах утгатай тайлагнасан.	1	21.4			1	21.4	1	21.4		
	Дүн	3	169,268.2	1	260.0	2	169,008.2	3	169,268.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Санхүүгийн тайлан хоцроосон.	1	-							1	-
2	Дансны үнэгүй хөрөнгийг шийдээгүй.	1	-					1	-		
	Дүн	2	-					1	-	1	-